МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/380 Мандалговь

Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансанд байршуулах мэдээллийг хавсралтын дагуу холбогдох хэлтэс агентлагуудад хариуцуулсугай.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаа, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Санхүүгийн хяналт, аудитын алба”-ны дарга (Г.Зоригт)-д, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн байршуулахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

48121051

Аймгийн Засаг Даргын 2021 оны 10 сарын
18 өдрийн А/380 дугаартай захирамжийн хавсралт

| № | Шилэн дансны мэдээллийн төрөл | Хариуцах хэлтэс, агентлаг |
|---|---|---|
| **1** | **Төсөв/Гүйцэтгэл** | |
| 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жилээр, Сар бүр/ | ХОХБТХэлтэс |
| 2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт (*Бүтэн жилээр*) | СТСХэлтэс |
| 3 | Дараа жилийн төсвийн төсөл (*Бүтэн жилээр*) | СТСХэлтэс |
| 4 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (*Бүтэн жилээр,Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр*) | СТСХэлтэс |
| 5 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (*Тухай бүр*) | СТСХэлтэс |
| 6 | Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (*Бүтэн жилээр,Бүтэн жилээр,Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр*) | Татварын хэлтэс |
| 7 | Санхүүгийн тайлан (*Бүтэн жилээр,Хагас жилээр*) | СТСХэлтэс |
| 8 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (*Бүтэн жилээр*) | СТСХэлтэс |
| 9 | Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (*Бүтэн жилээр, Сар бүр*) | СТСХэлтэс |
| 10 | Байгууллагын батлагдсан төсөв (*Бүтэн жилээр*) | СТСХэлтэс |
| **2** | **Хөрөнгө оруулалт,тендер, худалдан авалт** | |
| 1 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (*Бүтэн жилээр*) | ОНӨГазар |
| 2 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (*Бүтэн жилээр, Сар бүр*) | ОНӨГазар |
| 3 | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (*Тухай бүр*) | ОНӨГазар |

| | | |
|---|---|---|
| 4 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (*Тухай бүр*) | СТСХэлтэс |
| 5 | Худалдан авах ажиллагааны тайлан (*Бүтэн жилээр*) | ОНӨГазар |
| **3** | **Бусад** | |
| 1 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (*Тухай бүр*) | ХОХБТХэлтэс |
| 2 | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (*Бүтэн жилээр*) | СТСХэлтэс |
| 3 | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (*Тухай бүр*) | СТСХэлтэс |
| 4 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (*Тухай бүр*) | ОНӨГазар |